



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Бөмбөгөр сумын Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2022/31/НА-СТА-ТШЗ

Баянхонгор 2022 он	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: Д.Цэцэгмаа Утас: 88089024 Цахим хаяг: tsetsegmaa_1961@yahoo.vom Цахим хуудас: www.audit.mn
-----------------------	--

Агуулга

1. Аудитын гэрчилгээ /Эх хувь/.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн тайлан.....	11
3. Аудитын тайлан.....	12
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	13
3.4 Материаллаг байдал.....	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	15
3.8 Аудитын гол асуудал.....	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
4. Аудитын илрүүлэлт.....	16
4.1 Төлбөрийн акт.....	16
4.2 Залруулсан алдаа.....	17
4.3 Зөвлөмж.....	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Номгон 1 дүгээр баг, Баянхонгор сум,
Баянхонгор аймаг, 64101

Утас, факс 7044 2584

E-mail; bayankhongor@audit.gov.mn

2022.02.24 № 2/89

танай _____-ны № _____-г

Г АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ Г

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын Цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын Цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР  Б.МӨНХБАТ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

СТ-1А

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>75,521,798.80</u>	<u>82,175,554.22</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	75,521,798.80	82,175,554.22
351	Түүхий эд материал	46,331,843.13	52,245,598.55
35110	Тусгай зориулалттай материал	46,331,843.13	50,455,598.55
35130	Эм боох материал	00.00	1,790,000.00
354	Хангамжийн материал	29,189,955.67	29,929,955.67
35410	Бичиг хэргийн материал	148,300.00	148,300.00
35420	Аж ахуйн материал	28,621,655.67	29,524,655.67
35460	Хүнсний материал	00.00	47,000.00
35470	Бусад хангамжийн материал	420,000.00	210,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>621,004,228.83</u>	<u>605,074,552.73</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	621,004,228.83	605,074,552.73
392	Биет хөрөнгө	614,034,228.83	598,104,552.73
39201	Барилга, байгууламж, орон сууц	621,324,800.00	621,033,000.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-24,233,886.00	-38,047,913.76
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	33,762,878.36	28,819,119.46
39206	Хуримтлагдсан элэгдэл	-24,368,289.82	-18,767,150.28
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	26,116,443.00	20,948,302.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-20,457,985.71	-17,806,073.69
39217	Ном	1,890,269.00	1,925,269.00
393	Биет бус хөрөнгө	6,970,000.00	6,970,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	6,970,000.00	6,970,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>696,526,027.63</u>	<u>687,250,106.95</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>696,526,027.63</u>	<u>687,250,106.95</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	696,526,027.63	687,250,106.95
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	219,846,370.54	219,846,370.54
51101	Өмч: - төрийн	219,846,370.54	219,846,370.54
512	Хуримтлагдсан үр дүн	443,888,275.85	434,612,355.17
51210	Өмнөх үеийн үр дүн	443,888,275.85	443,888,275.85
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-9,275,920.68
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	32,791,381.24	32,791,381.24
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>696,526,027.63</u>	<u>687,250,106.95</u>

/Төгрөгөөр/

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

СТ-2А

Бөмбөгөр сумын Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	365,206,931.25	360,095,034.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,743,331.25	3,627,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	7,743,331.25	3,627,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,743,331.25	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	7,743,331.25	00.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого ҮХ		2,650,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого БМ		977,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	357,463,600.00	356,468,034.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	329,470,600.00	329,340,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,874,000.00	8,504,010.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,874,000.00	8,504,010.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	20,119,000.00	18,623,124.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	20,119,000.00	18,623,124.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	359,534,161.75	366,812,775.92
21	УРСГАЛ ЗАРДАЛ	359,534,161.75	366,812,775.92
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	335,418,426.75	344,520,703.92
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	231,534,959.00	248,194,275.00
210101	Үндсэн цалин	148,197,212.66	186,684,967.00
210102	Нэмэгдэл	46,015,305.34	27,402,594.00
210104	Урамшуулал	28,407,186.00	24,538,193.00
210105	Гэрээт ажлын хөлс	8,915,255.00	9,568,521.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,525,100.00	35,458,300.00
210201	Тэтгэврийн даатгал	22,887,900.00	34,074,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,409,300.00	345,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,927,500.00	276,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	481,900.00	69,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,818,500.00	691,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,720,106.00	16,288,074.00
210301	Гэрэл, цахилгаан	2,950,106.00	2,632,074.00
210302	Түлш, халаалт	14,620,000.00	13,656,000.00
210303	Цэвэр, бохир ус	150,000.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,981,581.25	9,899,057.58
210401	Бичиг хэрэг	981,281.25	874,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,000,000.00	1,530,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,422,000.00	1,416,713.00
210404	Ном, хэвлэл	26,400.00	18,900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	332,000.00	209,700.00

/Төгрөгөөр/

Бөмбөгөр сумын Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,219,900.00	4,037,150.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	1,812,494.58
2105	Нормативт зардал	24,972,350.00	13,224,700.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	926,400.00	2,796,300.00
210502	Хоол, хүнс	23,879,200.00	9,852,900.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	166,750.00	575,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	311,000.00	731,000.00
210604	Урсгал засвар	311,000.00	731,000.00
2107	Томилолт, зочны зардал	140,000.00	140,000.00
210702	Дотоод албан томилолт	140,000.00	140,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	250,000.00	1,050,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	700,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	350,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22,983,330.50	19,534,497.34
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,152,546.00	324,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,343,200.00	829,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	17,487,584.50	18,381,497.34
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	24,115,735.00	22,292,072.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,024,000.00	11,394,710.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	7,874,000.00	8,504,010.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,150,000.00	2,890,700.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	20,894.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	20,894.00	00.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	13,070,841.00	10,897,362.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,070,841.00	10,897,362.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>5,672,769.50</u>	<u>-6,717,741.92</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	2,558,178.76
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	00.00	2,558,178.76
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-2,558,178.76
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>5,672,769.50</u>	<u>-9,275,920.68</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

СТ-2А

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		

Бөмбөгөр сумын Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	357,463,600.00	356,468,034.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	357,463,600.00	356,468,034.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	329,470,600.00	329,340,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	329,470,600.00	329,340,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,874,000.00	8,504,010.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,874,000.00	8,504,010.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	20,119,000.00	18,623,124.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	20,119,000.00	18,623,124.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	355,188,600.00	354,108,034.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	355,188,600.00	354,108,034.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	331,072,865.00	331,555,962.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	231,534,959.00	248,119,225.00
210101	Үндсэн цалин	144,084,372.66	173,901,600.00
210102	Нэмэгдэл	47,970,522.34	29,192,925.00
210104	Урамшуулал	28,407,186.00	31,957,200.00
210105	Гэрээт ажлын хөлс	11,072,878.00	13,067,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,525,100.00	35,458,300.00
210201	Тэтгэврийн даатгал	22,887,900.00	25,603,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,409,300.00	2,463,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,927,500.00	1,970,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	481,900.00	492,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,818,500.00	4,927,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,098,106.00	18,123,124.00
210301	Гэрэл, цахилгаан	4,278,106.00	4,267,124.00
210302	Түлш, халаалт	14,620,000.00	13,656,000.00
210303	Цэвэр, бохир ус	200,000.00	200,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,264,600.00	5,236,813.00
210401	Бичиг хэрэг	135,600.00	200,600.00
210402	Тээвэр, шатахуун	1,000,000.00	1,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,417,300.00	1,416,713.00
210404	Ном, хэвлэл	75,300.00	75,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	332,000.00	239,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,304,400.00	1,804,400.00
2105	Нормативт зардал	30,101,100.00	15,575,700.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,306,400.00	5,000,300.00
210502	Хоол, хүнс	23,879,200.00	9,899,900.00

Бөмбөгөр сумын Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,915,500.00	675,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,751,000.00	6,406,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,520,000.00	5,675,000.00
210604	Урсгал засвар	2,231,000.00	731,000.00
2107	Томилолт, зочны зардал	140,000.00	140,000.00
210702	Дотоод албан томилолт	140,000.00	140,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,201,500.00	1,291,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	951,500.00	701,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	350,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	240,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,456,500.00	1,205,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,456,500.00	1,205,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	24,115,735.00	22,552,072.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,024,000.00	11,654,710.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	7,874,000.00	8,504,010.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,150,000.00	3,150,700.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	20,894.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	20,894.00	00.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	13,070,841.00	10,897,362.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,070,841.00	10,897,362.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>2,275,000.00</u>	<u>2,360,000.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	<u>2,275,000.00</u>	<u>2,360,000.00</u>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	<u>2,275,000.00</u>	<u>2,360,000.00</u>
2200	Дотоод эх үүсвэрээр	<u>2,275,000.00</u>	<u>2,360,000.00</u>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2,275,000.00	2,360,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-2,275,000.00</u>	<u>-2,360,000.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

СТ-4А

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Аудитын код: БНА-2022/31/НА-СТА-ТШЗ



Бөмбөгөр сумын Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	219,846,370.54	32,791,381.24	438,215,506.35	00.00	690,853,258.13
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	219,846,370.54	32,791,381.24	438,215,506.35	00.00	690,853,258.13
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	5,672,769.50	00.00	5,672,769.50
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	219,846,370.54	32,791,381.24	443,888,275.85	00.00	696,526,027.63
D01	2021 оны 01-р сарын 31-нээрх үлдэгдэл	219,846,370.54	32,791,381.24	443,888,275.85	00.00	696,526,027.63
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	219,846,370.54	32,791,381.24	443,888,275.85	00.00	696,526,027.63
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-9,275,920.68	00.00	-9,275,920.68
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	219,846,370.54	32,791,381.24	434,612,355.17	00.00	687,250,106.95

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТГ

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	356,508,300.00	337,066,662.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	356,508,300.00	337,066,662.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	353,357,600.00	333,915,962.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	248,357,800.00	248,119,225.00
210101	Үндсэн цалин	173,901,600.00	173,901,600.00
210102	Нэмэгдэл	29,431,500.00	29,192,925.00
210104	Урамшуулал	31,957,200.00	31,957,200.00
210105	Гэрээт ажлын хөлс	13,067,500.00	13,067,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35,458,300.00	35,458,300.00
210201	Тэтгэврийн даатгал	25,603,900.00	25,603,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,463,600.00	2,463,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,970,900.00	1,970,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	492,700.00	492,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,927,200.00	4,927,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,167,400.00	18,123,124.00
210301	Гэрэл, цахилгаан	4,278,700.00	4,267,124.00
210302	Түлш, халаалт	13,688,700.00	13,656,000.00
210303	Цэвэр, бохир ус	200,000.00	200,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,272,600.00	5,271,813.00
210401	Бичиг хэрэг	235,600.00	235,600.00
210402	Тээвэр, шатахуун	1,500,000.00	1,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,417,300.00	1,416,713.00
210404	Ном, хэвлэл	75,300.00	75,300.00

Бөмбөгөр сумын Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	239,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,804,400.00	1,804,400.00
2105	Нормативт зардал	26,233,100.00	15,575,700.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,000,300.00	5,000,300.00
210502	Хоол, хүнс	20,557,300.00	9,899,900.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	675,500.00	675,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,231,000.00	8,731,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,000,000.00	8,000,000.00
210604	Урсгал засвар	9,231,000.00	731,000.00
2107	Томилолт, зочны зардал	140,600.00	140,000.00
210702	Дотоод албан томилолт	140,600.00	140,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,291,500.00	1,291,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	701,500.00	701,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	350,000.00	350,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	240,000.00	240,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1205300.00	1205300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,205,300.00	1,205,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3150700.00	3150700.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,150,700.00	3,150,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,150,700.00	3,150,700.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	356,508,300.00	337,066,662.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	329,340,900.00	318,443,538.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	329,340,900.00	318,443,538.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	27,167,400.00	18,623,124.00
132001	Орон нутгийн төсвөөс	27,167,400.00	18,623,124.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	19.00	19.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	15.00	15.00
620003	Үйлчлэх ажилтан	03.00	03.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн тайлан

НТ-2

НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		8,504,010.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		8,504,010.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	8504010.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		8,504,010.00

Бөмбөгөр сумын Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		8,504,010.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	8,504,010.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		8,504,010.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		8,504,010.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Бөмбөгөр сумын Цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газартай хийсэн гэрээний үндсэн дээр “Глобал капитал аудит” ХХК-ийн аудитор Д.Цэцэгмаа гүйцэтгэж, чанарын хяналтыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Бөмбөгөр сумын Цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 11-ны өдрийн 04 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Санхүүгийн тайлант хугацаанд Цэцэрлэгийн эрхлэгч Б.Цэцгээ нэгдүгээр гарын үсгийг, нягтлан бодогч Б.Ганболд нар хоёрдугаар гарын үсгийг тус тус зурж хөрөнгө мөнгийг захиран зарцуулсан байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Бөмбөгөр сумын Цэцэрлэг нь бага насны хүүхдийг асрах, хамгаалах, хүмүүжүүлэх, сургах цогц үйл ажиллагаагаар хүүхдийн бие бялдар, оюун ухаан, нийгэмшихүйн хөгжлийг дэмжих, сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээг хүргэх зорилго зорилтыг хангах үүднээс сургуулийн өмнөх боловсролын үйл ажиллагааг хэвийн явуулах чиг үүргийг хэрэгжүүлж ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Бөмбөгөр сумын Цэцэрлэгийн эрхлэгчийн тушаалаар батлагдсан салбарын хэмжээнд мөрдөх хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтыг ашиглаж байна.

Тус байгууллага нь дотоод аудитын алба байхгүй бөгөөд дотоод аудитын чиг үүргийг аймгийн Санхүүгийн хяналт аудитын алба нь хэрэгжүүлдэг ба Бөмбөгөр сумын Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Бөмбөгөр сумын Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн үе шатны материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 366,912.8 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 5,347.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 4,010.4 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзэхэд 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцоход 4,126.6 мянган төгрөг байгаа тул шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Бөмбөгөр сумын Цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 687,250.1 мянган төгрөг болж өмнөх оноос 9,275.9 мянган төгрөгөөр буюу 1,3 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материалын данс, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	75,521.8	82,175.6	6,653.8
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-

Бөмбөгөр сумын Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	75,521.8	82,175.6	6,653.8
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	621,004.2	605,074.6	(15,929.7)
Үндсэн хөрөнгө	690,064.4	679,695.7	(10,368.7)
Хуримтлагдсан элэгдэл	(69,060.2)	(74,621.1)	(5,561.0)
Нийт хөрөнгө	696,526.0	687,250.1	(9,275.9)
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	696,526.0	687,250.1	(9,275.9)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	696,526.0	687,250.1	(9,275.9)

Бараа материалын дансны үлдэгдэл 82,175.6 мянган төгрөг болж 6,653.8 мянган төгрөгөөр өссөн нь тусгай зориулалтын материалын дансны үлдэгдэл өмнөх оноос 4,123.8 мянган төгрөгөөр, эм боох материал 1,790.0 мянган төгрөгөөр, аж ахуйн материал 903.0 мянган төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 679,695.7 мянган төгрөг болж 10,368.7 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 2,360.0 мянган төгрөгөөр тоног төхөөрөмж худалдан авч, сумын Засаг даргын тамгын газраас 2,000.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, Дэлхийн зөн Олон улсын байгууллагаас 650.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж үнэ төлбөргүй хүлээн авч, Аймгийн ИТХурлын 2021.12.14 ний өдрийн 137 тоот тогтоолоор 15,378.7 мянган төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хассантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 687,250.1 мянган төгрөг болж өмнөх оноос 9,275.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгийн бууралтаас шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй. Тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар 8,504.0 мянган төгрөгийн орлого, зарлагын гүйлгээ хийгдсэн байна.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 443,376.1 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 443,376.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 21,117.3 мянган төгрөгөөр бууруулж 422,258.8 мянган төгрөгөөр батлагдсан ба аймгийн Засаг даргын 2021.05.06-ний А/289 тоот, 2021.12.06-ны А/742 тоот захирамжуудаар төсвийн зохицуулалт хийгдэж 356,508.3 мянган төгрөг болж 65,750.5 мянган төгрөг буюу 15,4 хувиар буурч батлагдсан.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 356,508.3 мянган төгрөгийн төсөв баталснаас улсын төсвөөс 329,340.9 мянга, орон нутгийн төсвөөс 27,167.4 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 318,443.5 мянга, орон нутгийн төсвөөс 18,623.1 мянга нийт 337,066.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд зарцуулж 10,897.3 мянган төгрөг буюу 3,2 хувийг улсын төсөвт буцаан төвлөрүүлж, орон нутгийн төсвөөс авах санхүүгийн дэмжлэгийг 8,544.2 мянган төгрөгөөр дутуу авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 337,066.6 мянган төгрөг буюу 94,5 хувьтай байгаа нь норматив зардлыг 10,657.4 мянган төгрөг, урсгал засварын зардлыг 8,500.0 мянган төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмжинд 8,504.0 мянган төгрөгийг зохих журмын дагуу зарцуулсан байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд Ковид-19 цар тахалтай холбоотой цэцэрлэгийн үйл ажиллагаа БШУЯ, улсын болон аймгийн онцгой комиссоос өгсөн шийдвэр, чиглэлийн дагуу тусгай горимоор хичээллэсэн.

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд “Баянташаагийн эх аудит” ХХК –ний аудитор Т.Хоролсүрэн санхүүгийн тайлангийн аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 5 зорилт 34 арга хэмжээг төлөвлөж хэрэгжилт 94 %-тай гэж тайлагнасан байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 366,812.8 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 10,333.7 мянган төгрөгөөр буюу 2,9 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь хангамж, бараа материалын зардал, нормативд зардал буурсан үзүүлэлттэй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг

стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл"-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тайлант хугацаанд шилэн дансны мэдээллийн сайтад оруулбал зохих 151 мэдээллээс хугацаа болоогүй 2 мэдээлэл, мэдээлбэл зохих 149 мэдээллээс төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэлийн 25868.8 мянган төгрөгийн 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

3.9.2 Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Тайлант онд тогтмол зардалд анхны батлагдсан төлөвлөгөөгөөр 18,167.4 мянган төгрөг батлагдсан ба батлагдсан төсвийн 20 хувь нь 3,633.4 мянган төгрөг байна. Төсвийн гүйцэтгэлээр 44.2 мянган төгрөгийн хэмнэлт үүссэн байгаа нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын "1.8. байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 86,605.2 мянган төгрөгийн хүүхдийн хоол худалдан авах ажиллагааг сумын ЗДТГ зохион байгуулж, "Хонгор арвай" хоршоотой гэрээ байгуулсан байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн нэг заалт бүхий зөвлөмж өгснийг хэрэгжүүлж ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 2,367.2 мянган төгрөгийн 3 зөрчил илэрч, 529.7 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 2,437.4 мянган төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулж зөрчил дутагдлыг давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгөв..

4.1 .Төлбөрийн акт

4.1.1. Нягтлан бодогчийн 1,3-р улирлын үр дүнгийн урамшуулал цалинг үндсэн орон тооны ажилтны цалингаас бодож 529.7 мянган төгрөгийг илүү олгосон

Энэ нь "Журам батлах тухай" Монгол улсын Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан" Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"- 4.2. Энэ журмын 4.1-д заасан албан хаагч гэдэгт сургалтын байгууллагын төсвөөс цалинждаг орон тооны ажилтан хамаарна. 4.5.Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн албан хаагчид албан тушаалын сарын үндсэн

Бөмбөгөр сумын Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

цалингийн 15 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг сар бүр тооцож, улирал бүр олгоно.гэснийг зөрчсөн нь санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох ажилтнаар 529.7 мянган төгрөгийг буцаан төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

4.2. Залруулсан алдаа

4.2.1. Даатгуулагчийн төлөх НДШ-ийн 2,362,4 мянган төгрөгийг ажил олгогчийн төлөх НДШ-ийн зардлаас төлж, тайлагнасан, Цахилгааны зардалд төлсөн 75.0 мянган төгрөгийг цалингийн зардалд хаасныг санхүүгийн тайланд залруулав.

4.3. Зөвлөмж

4.3.1 Тайлант онд тогтмол зардалд анхны батлагдсан төсвөөр 18167,4 мянган төгрөг батлагдсан ба нийт батлагдсан төсвийн хувь нь 3633,6 мянган төгрөг байна. Тус онд 44,2 мянган төгрөгийн хэмнэлт үүссэн байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны 2021 оны 2 дугаар сарын 17-ны 43 дугаар тогтоолын “ 1.8. байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах” гэсэн заалтыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн: Цаашид дээд шатны байгууллагаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлж ажиллах.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		/мянган төгрөгөөр/							
				Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Бөмбөгөр сумын Цэцэрлэг	3	2967,1	1	2437,4	1	529,7			1	

_____оОо_____